**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 17 өдөр          Дугаар А/23          Чойр

Дайчин тугийн аяллыг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Батлан хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.1, Монгол Улсын Батлан хамгаалах сайдын 2019 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/82 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Халхын голын байлдааны ялалтын 80 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах яам, Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг "Улаанбаатар төмөр зам"-тай хамтран Халхын голын байлдаанд оролцсон цэргийн нэгтгэл, ангиудын "Дайчин туг"-ийн аяллыг 2019 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулсугай.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Нийгмийн бодлогын хэлтэст даалгах нь:

А. Аяллын хүрээнд аймаг, орон нутагт зохион байгуулах арга хэмжээнд 1939, 1945 оны дайн, байлдааны ажиллагаанд оролцсон орон нутгийн ахмад дайчид болон хүүхэд, залуучуудын төлөөллийг өргөнөөр оролцуулах;

Б. Аялалд оролцож байгаа бүрэлдэхүүний орон нутаг дахь тээвэрлэлтийн арга хэмжээг зохион байгуулах;

3. Аяллын бүрэлдэхүүний 20 хүний хооллолтыг зохион байгуулах ажилд дэмжлэг үзүүлэх зардлыг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргаж зарцуулахыг нягтлан бодогч /Б.Гүнжидмаа/-д зөвшөөрсүгэй.

4. Аяллын бэлтгэл ажлыг хангаж, үр дүнтэй зохион байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Цэргийн штабын дарга /хурандаа С.Бат-Эрдэнэ/, Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /С.Уранцэцэг/ нарт тус тус даалгасугай.

ДАРГА          Д.СОДНОМ

4021000111

Аймгийн Засаг Даргын Тамгын газрын даргын 2019 оны 04 дүгээр сарын 27.
–ны өдрийн А/22 тоот тушаалын хавсралт

"Дайчин туг"-ийн аяллын бүрэлдэхүүнийг хооллолтыг зохион байгуулах төсвийн задаргаа

| д/д | Зардлын нэр | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэг бүрийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|---|---|
| 1. | Өдрийн хоол | Хүн | 20 | 13000 | 260000 |
| 2. | Хорхог | 120000 | | | |
| 3. | ДҮН | | | | 380000 |

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН**
**ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН**
**ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 04 сарын 22 өдөр　　Дугаар А/24　　Чойр

Эцэг эхийн зөвлөл байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5.а, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, НҮБ-ын Хүүхдийн эрхийн конвенци, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 5 дугаар зүйл, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 28, 29 дүгээр зүйл, Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр", Хүүхдийн төлөө үндэсний зөвлөлийн 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 03 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Байгууллага, аж ахуйн нэгжийн дэргэд эцэг, эхийн зөвлөл байгуулж ажиллуулах зөвлөмж"-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын ажилтан, албан хаагчдын гэр бүл, хүүхдүүдэд чиглэсэн үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах, хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих талаар санал санаачилга гарган ажиллах чиг үүрэг бүхий зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

| | |
|---|---|
| Зөвлөлийн тэргүүн: | М.Анхбаяр (Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга) |
| Нарийн бичгийн дарга: | Г.Дашжаргал (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн) |
| Гишүүн: | М.Мөнхнаран (Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Д.Оюунсайхан (Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн) |
| | Г.Энххишиг (Хөрөнгө оруулалт,хөгжлийн бодлого төлөвлөтийн хэлтсийн мэргэжилтэн) |
| | Б.Өлзийдэлгэр |

4001000018

(Хяналт, шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтсийн мэргэжилтэн)
М.Мичидмаа
(Санхүү,төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн)
Т.Алтанцэцэг
(Нярав)
Н.Оюунбат
(Цэргийн штабын тоо бүртгэгч)

2. Хүүхдийн хөгжил хамгааллын үндэсний хөтөлбөр, хууль тогтоомж, дүрэм журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон, төлөвлөгөө гарган батлуулж, арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан, ажлын тайланг бүтэн жилээр Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлэн ажиллахыг Зөвлөлийн тэргүүн /М.Анхбаяр/-д үүрэг болгосугай.

ДАРГА Д.СОДНОМ

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 04 сарын 22 өдөр Дугаар А/25 Чойр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, эутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дундговь аймагт зохион байгуулагдах бүсийн "Уртын дуу"-ны тэмцээнд оролцох хүмүүсийн замын зардлыг хавсралтаар баталсугай.

2. Дээрх зардалд зарцуулах 430 000 /Дөрвөн зуун гучин мянга/ төгрөгийг нэг удаагийн дэмжлэг үзүүлэх зардлаас гаргахыг нягтлан бодогч /Б.Гүнжидмаа /-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Д.СОДНОМ

420219023

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 04 сарын 22 өдрийн А/35 дугаар тушаалын хавсралт

Дундговь аймагт болох уртын дууны уралдаанд оролцогчдын замын зардлын тооцооны хүснэгт

2019-04-02.

| № | Аймаг / явах маршрут / | Зай / км / | Зарцуулах бензин | Нийт үнэ |
|---|---|---|---|---|
| Нэг. 8-н хүний суудалтай машины зардал | | | | |
| 1. | Говьсүмбэр - Төв | 200 | 32 | 57600 |
| 2. | Төв - Дундговь | 225 | 36 | 64800 |
| 3. | Дундговь – Төв | 225 | 36 | 64800 |
| 4. | Төв – Говьсүмбэр | 200 | 32 | 57600 |
| 5. | Дундговь / дотор / | 120 | 14 | 25200 |
| | | 970 | 135.2 | 270000 |
| Хоёр. 5 хүний суудалтай унааны зардал | | | | |
| 1. | Говьсүмбэр - Төв | 200 | 20 | 36000 |
| 2. | Төв - Дундговь | 225 | 22,5 | 40500 |
| 3. | Дундговь – Төв | 225 | 22,5 | 40500 |
| 4. | Төв – Говьсүмбэр | 200 | 20 | 36000 |
| 5. | Дундговь / дотор / | 120 | 3,9 | 7020 |
| | | 970 | 97 | 160000 |
| | Нийт зардал | 1940 км | 232,2 л | **4300000** |

Жич: Нийт оролцох хүмүүсийн 13, Явах унаа 2 машин, 4 хоног